

Уламжлалт монгол барилаар хуурдах онцлогийг харьцуулан туршсан нь

Оюунбилэгийн Баттөгс 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Үндэсний урлагийн тэнхим, Улаанбаатар, Монгол Улс

✉ battugs495@gmail.com

Хураангуй: Энэхүү судалгааны ажлаар морин хуурын хуурдах арга барил нь монголчуудын уламжлалт тоглоом наадгайтай (шагай харвааны нясалгаа, сур харвааны нумын барил) уялдсан байдлыг тодруулж, улмаар уламжлалт монгол барилын онцлог болон Өвөр монгол морин хуурчдын нумын хоёр барилыг харьцуулж, дуугаралт, хэллэгийг тодорхойлохыг зорьсон.

Морин хуурын эгшгүүдийн цахилгаан дохиог судалж, үндсэн болон дагалдах өнгүүдийн давтамж, дуугаралтын түвшин зэрэг физик шинжүүдийг харьцуулсан болно. Эгшгүүдийн дуугаралтын цахилгаан дохионы үзүүлэлтүүд өвөр монгол барилын хувьд энергийн төвлөрөл сарнилт ихтэй бол монгол барилын хувьд энергийн төвлөрөл тогтвортой байна гэсэн гол үр дүн гарлаа. Энэ нь монгол барил дуугаралт цэвэр, сайн байгааг харуулж байна. Судалгаанд мэргэжлийн байгууллагын нийт 146 оюутан, ажилтан хамрагдсан. Судалгаанд оролцсон мэргэжлийн хуурчид 99% нь өвөр монгол нумын барилаар хуурдаж байгаа бол 52.5% хувь нь монгол нумын барил сурах шаардлагатай гэж хариулжээ. Оюутнуудын хувьд дийлэнх нь морин хуурын хөгжмийн хичээлийг цахим хэлбэрээр оруулсан байх, түүнчлэн аудио, видео бичлэг шаардлагатай гэжээ.

Эдгээрээс хуурдах соёлыг хойч үедээ өвлүүлэн үлдээж, мэргэжлийн морин хуурчид, их, дээд сургууль, мэргэжлийн байгууллага, морин хуурын сургалтын төвүүдэд уламжлалт монгол нумын барилын давуу талыг танин мэдүүлж, цаашид судалгаа, шинжилгээ хийх шаардлагатай гэж үзлээ.

Түлхүүр үгс: нумын барил, дуугаргалтын энергийн тархалт, цохилго, хуурын татлага, нумын хэмжээс

A Comparative experiment on the features of traditional Mongolian bowing technique

Battugs Oyunbileg 

Department of National Arts, School of Music and Arts,
Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ battugs495@gmail.com

Abstract: This study aims to identify the connection between the bowing technique of the Morin khuur and traditional Mongolian games (flicking in shagai shooting and the bow grip in archery). It further seeks to compare the features of the traditional Mongolian bowing style with that of Inner Mongolian Morin khuur players, focusing on differences in sound production and articulation. The study analyzed the electric signals of the Morin khuur tones, comparing the physical characteristics such as the frequencies and sound levels of the fundamental and overtone components. The main finding is that the energy distribution of sound signals in the Inner Mongolian technique is more dispersed, while in the Mongolian technique, the energy concentration is more stable. This indicates that the Mongolian bow-hold produces clearer and better-quality sound. A total of 146 students and staff from a professional institution participated in the research. Among the professional players surveyed, nearly all (99%) using the Inner Mongolian bow-hold, while more than half (52.5%) stated that it is necessary to learn the Mongolian bow-hold technique. Most students expressed a need for Morin khuur lessons to be provided online and supported with audio and video materials. The study concluded that there is a pressing need to preserve and pass on the traditional bowing culture to future generations. It is also recommended that professional Morin khuur players, universities, professional institutions, and training centers raise awareness of the advantages of the traditional Mongolian bow-hold and continue conducting further research and analysis.

Keywords: *bow grip, distribution of sound-producing energy, articulation (stroke), string tension, and bow dimensions*

Оршил

Орчин цагт морин хуурын сургалтыг ихэвчлэн Монгол Улсын морин хуурч, багш Г.Жамъяаны боловсруулан гаргасан тогтолцоот сургалтын аргаар явуулж байна. Өнөөгийн морин хуурын сургалтад ном, сурах бичиг, бусад хэрэглэгдэхүүнийг ашиглахаас гадна судлаачдын судалгааны ажлуудыг ашиглах явдал их болсон.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд морин хуурын нумын барил, эгшгүүдийн цахилгаан дохиог судалж, үндсэн болон дагалдах өнгөнүүдийн давтамж, дуугаралтын түвшин зэрэг физик шинжүүдийг харьцуулсан. Морин хуурын нумын барил нь хөгжимчин нумыг хэрхэн зөв байрлуулах, хуурдах, ашиглахтай холбоотой ойлголт бөгөөд дуугаралт, өнгө аяс, хэллэг, техник гэх мэтэд нөлөөлдөг маш чухал элемент юм. Судалгаанд мэргэжлийн байгууллагын нийт 146 оюутан, ажилтан хамрагдсан. Судалгаанаас үзэхэд, морин хуур нь монголчуудын уламжлалт тоглоом наадгайтай (шагай харвааны нясалгаа, сур харааны нумын барил) холбогдож байна.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь мэргэжлийн морин хуурчид, хуурын сургалтын төв, их, дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудад, цаашлаад хойч үедээ уламжлалт монгол нумын барилыг өвлүүлэн үлдээх, сурталчлахад оршино. Морин хуурын нумын зөв байрлал, барил, хөдөлгөөнийг эзэмшсэний үр дүнд хөгжимдөх ур чадвар сайжрахаас гадна хөг аялгуу сайтай болж, дуугаралтын эгшиг, хэллэгүүд сайжирдаг. Судалгааны ажлын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд,

- Морин хуурын нум барих арга, аргачлал, дуугаралт, хэллэгийг тодорхойлох, барилуудыг харьцуулах,
- Морин хуурын нумын барилуудын эгшгүүдийн дуугаралт, тэдгээрийн энергийн тархалтыг судлах,
- Мэргэжлийн морин хуурчдаас авсан судалгаа, түүний үр дүн,
- Морин хуурын барил нь уламжлалт наадгайтай (шагай харвааны нясалгаа, сур харааны нумын барил) холбогдох нь гэх мэт орно.

Судалгааны арга зүй

Судалгаанд дэвшүүлсэн зорилтуудыг биелүүлэхийн тулд Монгол Улсын болон өвөр монголын морин хуурчдын хуурдах онцлогтой холбогдох мэдээллийг баримтын болон ажиглалтын арга, сургалт туршилт хийгээд асуулга, ярилцлага, мөн харьцуулалтын аргуудыг хэрэглэлээ.

1. Туршилтын арга: Судалгааны ажлын таамаглалыг шалгахын тулд мэргэжлийн морин хуурчид болон суралцагчдыг хамруулсан нээлттэй хичээлээр уламжлалт нумын монгол барил болон өвөр монгол барилыг харьцуулан туршиж, үр дүнг тооцох, Соёл, урлагийн их сургууль (СУИС)-ийн оюутны ардын барилын хичээл зэрэгт эдгээр аргыг хэрэглэсэн болно. Туршилтад нийт 26 оюутан хамрагдсан.
2. Физикийн дуу долгионы онолд тулгуурлан физик шинжүүдийг Praat 6 программ ашиглан боловсруулалт хийж, дууны түвшин, давтамж зэргийг тодорхойлов.


Судалгааны үр дүн

Нэг. Мэргэжлийн морин хуурчдын хуурдах ур чадварт уламжлалт нумаар хуурдах арга хэрхэн нөлөөлөх онцлогийг турших, үр дүнг тодруулах үүднээс СУИС, Морин хуурын чуулга, Монгол Улсын консерватори (МУК), Түмэн эх чуулга, Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга (ХЦДБЧ), Бүх цэргийн дуу бүжгийн чуулга (БЦДБЧ), Монгол Улсын Үндэсний урлагийн их театр (МУҮУИТ), Монголын хүүхдийн ордон гэсэн мэргэжлийн урлагийн байгууллагын морин хуурчид болон мэргэжлийн ангийн оюутнуудаас бүрдсэн 146 хуурчийг хамруулав.

Хүснэгт 1. Мэргэжлийн морин хуурчдын нумын барилын судалгаанд хамрагдсан байдал (2024 он), тоон үзүүлэлтээр

Байгууллагын нэр	Хөгжимчдийн тоо	Монгол барил	Өвөр монгол барил
Морин хуурын чуулга	16		16
СУИС	30	2	28
МУК	31		31


Түмэн эх чуулга	3		3
ХЦДБЧ	7		7
БЦДБЧ	3		3
МУҮУИТ	8		8
Монголын хүүхдийн ордон	48		48
НИЙТ	146	2	144



Зураг 1. Мэргэжлийн морин хуурчдын нумын барилын судалгаанд хамрагдсан байдал, хувиар


Судалгаанд хамрагдсан мэргэжлийн морин хуурчдын дунд одоо үед монгол нумаар хуурдах нь ховордсон байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна. Жишээлбэл, МУ-ын Морин хуурын чуулга 16 хуурч байгаагаас бүгд өвөр монгол нумын барилаар хуурдаж байна.

Хоёр. Морин хуурын мэргэжлийн ангийн 26 оюутныг хамарсан хуурын монгол барилын хэрэглэгдэхүүний хэрэгцээг тодруулах зорилго бүхий нээлттэй хичээлийг Ардын жүжигчин Ч.Батсайхан, өвөр монголын морин хуурч Чи Бөхөө нартай хамтран 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдөр СУИС-ийн 300в танхимд зохион байгуулав. Энд сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүний хэрэгцээг илрүүлэхээс гадна ямар хэрэглэгдэхүүн хэрэгцээтэй байгааг “Морин хуур хөгжимдөж сурахад хуурын монгол барилын хэрэгцээ шаардлагатай байна уу?” гэсэн нээлттэй асуултаар тодрууллаа.




Зураг 2. Морин хуурын нумыг сурахад хэрэгцээтэй байгаа хэсэг

“Морин хуурын нэмэлт хэрэглэгдэхүүнд оюутнууд концерт, аудио болон видео бичлэг байвал тэдэнд морин хуурын нумын талаар суралцахад илүү дэмжлэг болно” гэдгийг дурджээ. Тухайлбал, асуулгад хамрагдсан нийт оюутнуудын 92.21% нь морин хуурын хөгжмийн аяг цахим хэлбэрээр оруулсан байх, аудио болон видео бичлэг, хичээл шаардлагатай гэж үзсэн харгалзан 98.72% болон 96.1% байна.




Зураг 3. Морин хуурын нумыг сурахад нэмэлт хэрэглэгдэхүүн

Гурав. Морин хуурын бага наймцын фа эгшгийн дуугаралтын энергийн тархалт: Микрофоны тусламжтай морин хуур зэмсгийн дууны хэлбэлзлийг тоон дохио болгон хөрвүүлж, дуу бичлэгийн төхөөрөмжийн тусламжтайгаар дууны файл (wave file) болгон хадгаллаа. Дууны файл болгосон морин хуур зэмсгийн эгшиг дуурьслыг компьютерын Praat 6 программ ашиглан боловсруулалт хийж, дууны түвшин, давтамж зэргийг тодорхойлов.



Зураг 4. Өвөр монгол барил



Зураг 5. Монгол барил

Судалгааг цааш нарийвчлан энерги нь хэрхэн тархаж байгааг судалсан. Энэхүү зургаас харахад, монгол барилын дуугаралт нь илүү цэвэр сарнил байхгүй буюу тогтвортой, шулуун байна. Өөрөөр хэлбэл, илүү цэвэр дуугаралттай байгаа нь харагдаж байна.

Хэлэлцүүлэг

Нэг. Уламжлалт морин хуурын сургалтын хэлбэр. Уламжлалт морин хуурын сургалтын өөрчлөлт нь монголын язгуур урлагийн өв залгамжлалтай холбоотой байдаг. Учир нь монголын язгуур хөгжмийн нэг хэсэг болохын хувьд уламжлалт морин хуурын өв залгамжлал нь монголын үндэсний хөгжмийн өв залгамжлалын зөвхөн нэг тал юм.

Эгшиглүүлэх учир: Хуурдахын нэр нь хөрөөдөхдөө бус, чухамдаа дуугарахдаа байна. Дуугаргана гэдэг нь дүрээр сэтгэнэ гэсэн үг юм. Ийм учраас хөгжмийн эгшиг дуун гэж юу вэ гэвэл хөгжмийн уран сайхны дүр бүтээх үндсэн материал, утга илэрхийллийн гол хэрэглүүр, хөгжмийн сэтгэлгээний амьд хэл мөн.

Морин хуурч, ер нь аль ч үндэснийх байлаа ч нумт хөгжмийн аливаа төрөлд хамаарах бүхий л хөгжимд, дуурьсан дуугаргах хоёр үндсэн арга байдаг. Үүнд:

1. Хөгжмийн чавхдас, нум хоёрын үйлчлэл
2. Хоёр гарын зохицолдоо

Энэ бол хөгжмийн чавхдасыг зөвхөн дуугаргахын анхны алхам болохоос биш эгшиглүүлэхийн бүрэн утгыг хараахан харуулж чадахгүй юм. Хөгжмийн эгшиг дууг жинхэнэ ёсоор нь уран сайхны дээд зэргийн чанар байдалтайгаар эгшиглүүлэхэд дээрх аргаас салбарлан үүсэх зөвхөн хөгжмийн утас нум хоёрыг нийцүүлэх дасгал гэхэд л утас нум хоёрын хөндлөн огтлол (нумын тэгш налуу), нумын дарах хүч (чанга, сул), нумын тасралтгүй үргэлжлэх хурд хугацаа (удаан, түргэн), нумын өнгө илчлэл (уянгалаг зөөлөн, огцом, хурц, бүдэг, хахир гэх мэт), хуурын эгшиглэлтийн төв зэргээс гадна бусад олон хүчин зүйл байдгийг сурган хүмүүжүүлэгч нар багшлах арга зүйдээ цаг ямагт анхаарч ажиллах ёстой (Жамьян 1978).

Суудал, байрлал: Хуурдах явцад хөгжимчнөөс хөгжимтэйгөө харьцаж байгаа бүхий л үйл ажиллагаа өөрөөр хэлбэл, биеийн чөлөөт байдал, баруун зүүн гарын барил, түүний гадаад төрх хэлбэр, хөдөлгөөний шилжилт, суудал байрлал зэргийг ерөнхийд нь тавил гэдэг ойлголтод хамаатуулж болно (Зураг 6).

Барил тавил: Морин хуурын тавилыг үндсэн гурван хэсэгт хувааж үзнэ. Үүнд:

1. Суудал, хөгжмийн байрлал
2. Баруун гарын барил
3. Зүүн гарын барил (Жамьян 1978, 7).



Зураг 6. Суудал, барил



Зураг 7. Баруун гарын барил

Баруун гарын барил: Баруун гарын барилд нумын ерөнхий барилд нумын янз бүрийн хөдөлгөөнөөс үүсэн гарах мөр, тохой, бугуй байрлал, хөдөлгөөнүүд хамаарагдана (Зураг 7). Нумын барилыг зөв тавих асуудал нь хуурчийн хөгжимдөх ур зүй, эгшиглүүлэх арга зүйтэй салшгүй холбоотой. Өөрөөр хэлбэл, баруун гарын уран чадвар бол нумын өнгө илчлэл, эгшиглүүлэхийн үндсэн ур зүй юм.

Морин хуурын нумыг барихдаа нумын бариулыг нумын хялгасны хамт атгах байдлаар 1, 2, 3, 4-р хуруу утсыг доош нь дарж эрхий ба 1-р хуруу нумыг тогтоож барина. Үүний тул нумын хялгас харьцангуйгаар сул бэхлэгдсэн байдаг.


Нумт хөгжимд нумыг татах түлхэх ерөнхий хоёр үйл явц байдаг. Морин хуур хөгжмийн нумын татах түлхэх үйл ажиллагаанд 5 хуруу бараг адил үүрэгтэй оролцдог. Харин хөгжимдөж байгаа арга барилаас шалтгаалж хуруу тус бүрийн гүйцэтгэх үүрэг харилцан адилгүй байна.

Морин хуурын чавхдас, нумын хялгасны өтгөн нь бараг тэгш харьцаатай байна. Ийм учраас хөгжмийн чавхдасанд нумын дарах (чангаар) хүч өөрөөр хэлбэл, хуурын чавхдасыг нумаар хөндлөн огтлол хийж гаргах эсэргүүцэл их байдаг. Ийм учраас морин хуурын нумыг бүхэлд нь атгах байдлаар тогтоон барьж хөгжимддөгийн учир энэ болой.

Ер нь морин хуурчийн 10 хуруу эгшиг дуунд онц мэдрэмтгий байх ёстой. Хөгжмийн зохиолын амьд хэл-уран сайхны эгшиг дууг үнэн бодитойгоор эгшиглүүлэхэд хуурчийн хурууны мэдрэмтгий чанар нь эгшиг дууг хянах эрхтэн чихнээс дутуугүй зохицуулах үүрэгтэй юм.

Баруун гарын бугуй, мөр тохой хөдөлгөөний байрлал нь хөгжимдөх ур зүй, тоглолтын шаардлага, нумын утга илэрхийллийн аргаас шалтгаалж янз бүр байдаг. Бугуй хөдөлгөөн нь нумын утга хурд хүч, хуурын эгшиглэлтийн төвийг тохируулахад чухлаар нөлөөлнө.

Нумыг татахад суга харьцангуй тэлэгдэж тохой урагшилна. Мөрний булчингийн уян хатан чөлөөтэй байдал нь баруун гарын тавилд улам ч аятай нөхцөлийг бүрдүүлнэ (Жамьян 1978, 8).



Зураг 8. Баруун гарын барил

Хурууны бүтэц ба үүрэг (Зураг 8) Хуруу, сарвууны артерийн судасны бүтцээс хамааруулан гурван бүс болгосон ангилал (Богомоллов, Седов 2003).

Хуруунуудын үүрэг хоорондоо ялгаатай байдаг. Ихэнх судлаачид сарвууны үйл ажиллагаанд эрхий хуруу 40-50%, долоовор хуруу 20%, дунд хуруу 15%, ядам хуруу 10%-ийн үүрэг гүйцэтгэдэг гэжээ. Зарим судлаачид дээрх хувиас бага зэрэг ялгаатай гэж үздэг. Эрхий хуруу угийн шивнүүрээр 75%, бусад хуруунууд 45%-аар тухайн хурууны хувьд үйл ажиллагаа нь алдагддаг гэж үздэг (Баатаржав 2008, 18).

II-IV хуруу үзүүрийн үе нь хөдөлмөрийн чадвараа 45% алдана. Мөн хуруунуудын угийн үеийн мэдрэлийн түвшин гэмтсэн бол 80%-аар үйл ажиллагааны алдагдалтай гэж үздэг. Харин мэдрэлжилт бүрэн алдагдсан бол сарвууны үйл ажиллагаа 50% алдагдсан гэж үзсэн. I, II, III, IV, V хуруунууд тайрагдаж тасарсан бол 40%, 20%, 10%, уг хуруунууд хэвийн мэдрэлжилт бүрэн алдсан бол 20%, 10%, 5% байна. Сарвууны бүх үйл ажиллагааг 100% гэж үзээд мэдрэхүй, хөдөлгөөнийг тус бүр 50%-тай тэнцүү гэж авч үзсэн (Баатаржав 2008, 89).

Хоёр. Морин хуурын эгшиг дуурьсалд нумын барил нөлөөлөх нь

Морин хуурын урын сангийн хөгжилд хөгжмийн зохиолчдын бүтээлүүд ихээхэн үүрэгтэй. Тухайн хөгжмийн зэмсгийг хуурдах арга барил, эгшиг дуурьслын онцлогоос шалтгаалж, хөгжмийн зохиолчдын шинэ арга барилыг практикт нэвтрүүлэх болжээ. Энэ нь хуурчдын ур чадварыг сайжруулахаас гадна хөгжмийн бүтээлээс шалтгаалж шинэ хэллэг, шинэ арга барилыг оруулж өгч байна.

Морин хуур зэмсгийн гол эд анги болох нумыг эхэн хэсэг, дунд хэсэг, адаг хэсэг гэж хуваан үздэг ба морин хуур зэмсгийн эгшиг дуурьсалд нумаар тоглох арга барил чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, нумын барилаас шалтгаалж, дууны түвшин, үндсэн өнгийн дуугаралт буюу дууны чанар, хэллэг (штрих) зэрэг олон зүйлс шалтгаалдаг.

Морин хуурын нумын монгол барил (Пүрэвхүү 1993) (Зураг 9)-аар хуурдах арга нь хөгжимчнөөс маш нарийн ур эзэмшихийг шаарддаг.

Давуу тал:

1. Хөгжмийн эгшгийн хүчдэл, даралтыг тод гаргадаг (даралт болон өнгө дуугаралт).
2. Татлага, уртын дуунд шаардагдах хэллэг, арга нь барилд илүү тохиромжтой мөн тодорхой хүчдэл ихсэж, бүтээлийн илэрхийлэлд нөлөөлдөг онцлог юм (Бум-Эрдэнэ 2017).
3. Дунд хуруу буюу 3 хурууны даралт нь хүчний тэнцвэрийг тогтвортой байлгадаг.
4. Нумыг татах (Эрдэнэчимэг 1994), түлхэх хүчийг нэмэгдүүлж хүчдэлийн тэнцвэртэй байдал үүсгэнэ.
5. Гурван хурууны жигд даралт үүссэнээс эрхий хуруу, долоовор хуруун үе дээр даралт үүсэж, нум сууж өгнө. Тэгснээр баруун гарын бугуй суларч хүчдэл ихсэж даралт үүснэ (Баттөгс 2018, 50).



Зураг 9. Монгол барил

Өвөр монгол барил (Зураг 10) нь 1990 оноос БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орноос манай улсад нэвтэрсэн ба сонгодог хөгжмийн зэмсгийн хэрэглэгдэхүүн болсон нумын шинэ хэлбэр хийцийг ашиглаж эхэлсэн (Өлзийбаяр 2001). Монгол барилыг бодвол эрхий болон долоовор хурууны завсар тулгуур модоо байрлуулдаг.

Энэхүү барил нь хэд хэдэн давуу талтай (Баттөгс 2018, 51). Үүнд:


- Уг нуман хялгасыг чангалах, суллах тулгуур модыг ашигласан (Мөнхбаяр 2007).



Зураг 10. Өвөр монгол барил

- Мөн савхан урт модыг нуман хэлбэртэй (трост) болгон ашигласан нь нумын дэвшилтэт тал нь болно.
- Дэлхийн сонгодог зохиол хөгжимдөхөд маш дөхөмтэй, төвөггүй, хэллэг (Оюунбадрах 2014, 54) (стаккато, спиккато буюу ойлгох, үсэргэх) гаргахад гол хүчин зүйл нь болсон.

Гурав. Монголчуудын уламжлалт тоглоом наадгайг морин хуурын барилтай холбох нь



Зураг 11. Сур харваа

Сур харвааны нумын барилт хөвч таталт. Сайн харвалтын арга барилыг сайн эзэмших явдал сайн харваач болох хамгийн чухал хэсгийн нэг. Нумын бариулыг зүүн гарын эрхий хурууны угаар тулган эрхий хуруу, долоовор хуруу хоёроороо зөөлхөн атгаж тулгаж барина. Зарим үед атгаж барилгүй нумд оосор хийж эрхий, долоовроороо хавчиж барих арга бий. Энэ аргыг олонх харваачид сонгодог (Балдандорж 1976, 112).

Хөвчийг баруун гарын долоовор, дунд, эрхий гурван хурууны анхны үеэр байрлуулан (3 хуруу ижил хүчтэй татсан байх хэрэгтэй) татна. Анхны байдлаар нэгэн хэмд байлгана (Балдандорж 1976, 113). Техникийн элементүүдийг хэрэглэн хувааж алхам алхмаар үйлдүүлэх. Үүнд: Үндсэн зогсолт-нум барих-сум онилох-эрхийвчлэх-нудрага зоох-амьсгал авч түгжих-таталт хийх-мэдрүүлэг мэдрэх-барьж зогсох-хараалах-мэдрүүлэг татал шалгах-мулталгаа хийх (Батхуяг 2007, 100).

Шагай харвааны нясалгаа, барил.

Шагайн харвааны ерөнхий нясалгаа бол дунд хурууны дунд үений өмнүүрх нь эрхий хуруугаараа эрхийвчлээд, хашлаганд дээрх сумын ард аажуухан очиж, дунд хуруугаа гүйцэд байрлуулах бөгөөд дунд хурууны урд үеийг хашлаганы ул хамрын зааг руу дарж, үзүүрийн дараагаа мэдрээд, долоовор болон ядам хуруугаа урагш зүтгүүлж, харвах хуруунд хөвчрөл үүсгэн уян чанарын хамгийн эцсийн мөчид эрхий хурууг удаалгүй имрэн мулталж нясалдаг.

Зөв нясалсан тохиолдолд гарын бугуй урагш сумаа дагаад аяндаа буудаг, дунд хуруу үзүүр дарсан газар эрхий хуруу үлддэг байна. Мөн сумны өшиглүүр хэсэгт гарсан хумсны ором зураасыг ажиглавал аль болох тэгш байх нум хэлбэр үүсгэн тасралтгүй зурагдсан байх нь зөв бөмбөг атгасан мэт бөөрөнхий хөндий үүсгэсэн байх ёстой гэдэг (Мөнхдэлгэр, Мягмарсүрэн, Жавзансүрэн 2021, 98). Үүнийг хадгалахын тулд сумаа байнга нэг цэгт тавих, сумны ард хуруугаа мөн байнга нэг цэгт байрлуулах шаардлагатай болно. Энэ харвааны болон гарын баримжаа маш их шаарддаг үйлдэл юм (Мөнхдэлгэр 2024, 43).



Зураг 12. Шагай харваа

Монголчуудын уламжлалт тогтоом наадгай нь морин хуурын монгол барил, техник, хурууны барилтай төстэй байна. Монголын эртний тоглоом наадгай нь онол, техник, арга нь зөв хэмээн үзвэл морин хуурын монгол барилын онол техник, арга нь зөв хэмээн үзэж болно.

Дүгнэлт

1. Судалгаанаас үзэхэд, мэргэжлийн байгууллагын 146 оюутан, ажилтан хамрагдсанаас 99% нь өвөр монгол нумын барилаар хуурдаж байгаа бол талаас илүү (52.5%) хувь нь монгол нумын барил сурах шаардлагатай гэж хариулжээ. Оюутнуудын хувьд дийлэнх нь морин хуурын хөгжмийн хичээлийг цахим хэлбэрээр оруулсан байх, түүнчлэн, аудио, видео бичлэг шаардлагатай гэжээ.
2. Морин хуурын нумын барилт (нум барих техник) нь хөгжим илэрхийлэх үндсэн суурь чадвар бөгөөд тоглолтын өнгө, дуугаралт, хэллэгийг тодорхойлох нөлөөлж байна. Мөн гурван хурууны жигд даралт үүссэнээс эрхий хуруу, долоовор хуруун үе дээр даралт үүсэж, нум сууж өгнө. Нумыг зөв өнцгөөр, тохирсон даралттай барьж тоглосноор хөгжмийн дуугаралт цэвэр, хүчтэй, уянгатай болж байна. Иймээс морин хуурын нумыг монгол барилаар татлага, уртын дуу, ардын дуу хөгжимдөхөд илүү тохиромжтой нь тогтоогдсон.
3. Өвөр монгол болон монгол нумын барилуудын хувьд эгшгүүдийн дуугаралтын цахилгаан дохионы үзүүлэлтүүд болох үндсэн өнгөний давтамж, дагалдах өнгөний давтамжууд, дууны түвшин бараг адилхан байсан ч өвөр монгол барилын хувьд энергийн төвлөрөл сарнилт ихтэй бол монгол барилын хувьд энергийн төвлөрөл тогтвортой байсан. Энэ нь монгол барил нь дуугаралт цэвэр, сайн байгааг харуулж байна.
4. Монголчуудын уламжлалт тогтоом наадгай нь морин хуурын монгол барил, техник, хурууны барилтай төстэй байна. Монголын эртний тоглоом наадгай нь онол, техник, арга нь зөв хэмээн үзвэл морин хуурын монгол барилын онол техник, арга нь зөв хэмээн үзэж болно. Мэргэжлийн морин хуурчид, их, дээд сургууль, мэргэжлийн байгууллага, морин хуурын сургалтын төвүүдэд уламжлалт монгол нумын барилын давуу талыг танин мэдүүлж, цаашид судалгаа, шинжилгээ хийж, хойч үедээ өвлүүлэн үлдээх шаардлагатай байна.

Ашигласан материалын жагсаалт

- Баттөгс, О. 2018. “Морин хуур зэмсгийн дуулдахуй болон цахилгаан дохионы үзүүлэлтийн судалгаа.” Ph.D дисс., Соёл урлагийн их сургууль.
- Баатаржав, С. 2008. “Хуруу, сарвууны тасарсан гэмтлийг нөхөн сэргээх мэс заслын эмчилгээг боловсронгуй болгох.” Ph.D дисс., Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль.
- Дансангийн, Хөгжимт. 2024. *Дөрвөн утаст хуурын төрөл зүйл, хуурдах арга барилын уламжлал шинэчлэл*. Улаанбаатар.
- Жамьян, Г. 1978. *Морин хуур сурах гарын авлага*. Улаанбаатар.
- Мөнхбаяр, Х. 2007. “Нумаар хөгжимдөх арга техникийн асуудал.” Магистрын судалгааны ажил. Соёл урлагийн их сургууль.
- Мөнхдэлгэр, Ж., Мягмарсүрэн, Г., Жавзансүрэн, П. 2021. *Монгол шагай харваа*. Улаанбаатар.
- Мөнхдэлгэр, Жигжжав. 2024. “Монгол шагай харвааны өв уламжлал, зан үйлийн судалгаа.” Ph.D дисс., Соёл урлагийн их сургууль.
- Оюунбадрах, Б. 2014. “Төгөлдөр хуурын зохиолыг боловсруулах асуудал.” Ph.D дисс., Соёл урлагийн их сургууль.
- Өлзийбаяр, Ш. “Морин хуурын аймгийн хөглөгөө болон хуурдах арга.” Морин хуурын анхдугаар их наадмын хурал. USA, 2001.
- Пүрэвхүү, Ц. 1993. “Морин хуурын тоглох арга барил.” Магистрын судалгааны ажил. Соёл урлагийн их сургууль.
- Эрдэнэчимэг, Л. 1994. *Хуурын татлага*. Улаанбаатар.

Ярилцлага:

- З.Бум-Эрдэнэ, З.Дагмидтай хийсэн “Татлага хуурдах онцлог”-ийн талаарх ярилцлага. 2017.12.27. Улаанбаатар.